



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.8, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газарт БНХАУ-ын Засгийн газраас олгож буй 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчийн ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулж, томилуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Б.Отгонцэцэг - Санхүү, хөрөнгө оруулалтын газрын  
Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн  
дарга

Гишүүд:

Д.Чимидлхам - Төрийн захиргааны удирдлагын газрын  
ахлах шинжээч

С.Ариунболд - Бодлого, төлөвлөлтийн газрын  
Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн ахлах  
мэргэжилтэн

А.Отгонбаатар - Төрийн захиргааны удирдлагын газрын  
Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ч.Төгөлдөрбалжир - Санхүү, хөрөнгө оруулалтын газрын  
Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн  
Төсөл хөтөлбөр хариуцсан шинжээч

2. Ажилтныг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг/ Б.Отгонцэцэг/-т үүрэг болгосугай.

170600125

3. Сонгон шалгаруулалттай холбоотой материалуудыг архивын нэгж болгон бүрдүүлж, архивд хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ч.Төгөлдөрбалжирт даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



Б.НАСАНТОГТОХ

